




Монголын Үндэсний Худалдаа
Аж Үйлдвэрийн Танхим

COVID-19

АЖЛЫН БАЙРНААС ХАМААРАХ ИРГЭДИЙН ОРЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ

судалгааны тайлан

2020 оны 4 сарын 20





АГУУЛГА

ХУРААНГУЙ.....	3
1. Гэр бүлийн орлого дахь нөлөө	4
2. Гэр бүлийн ба иргэдийн хуримтлал	7
3. Иргэдийн орлогыг хамгаалах арга хэмжээний үр нөлөө	9
4. Оролцогчдын мэдээлэл	10




ХУРААНГУЙ

1. Covid-19 вирусийн халдвар, тархалтаас сэргийлэх арга хэмжээтэй холбогдуулан ажлын байранд өөрчлөлт орсон тохиолдолд иргэдийн орлогын өөрчлөлтийг тодорхойлох зорилгоор иргэдийн орлогын өөрчлөлт, УИХ, ЗГ-ын шийдвэрийн нөлөө, цаашдын хүлээлт зэргийг тодруулан асууж, судалгааны үр дүнг нэгтгэлээ. Судалгааг 2020 оны 4 сарын 10-13 хугацаанд 10105 иргэдээс судалгаа авч түүврийн шаардлага хангасан 9043 иргэний мэдээллийг нэгтгэв.
2. Судалгаанд оролцогсдын 43 хувь нь 25-34 насны, 26 хувь нь 40-49 насны, 18 хувь нь 35-39 насны ангилалд байна. Мөн иргэдийн 48 хувь нь 700 мянган төгрөг хүртэлх өрхийн орлоготой, 25 хувь нь 701 мянга-1 сая хүртэлх, 21 хувь нь 1-2 сая төгрөгийн орлоготой ба 40 хувь нь хувийн компанид, 16 хувь нь хувиараа бизнес эрхэлдэг, 16 хувь нь төрийн байгууллагад ажилладаг байна.
3. Covid-19 вирусийн халдвараас сэргийлэх арга хэмжээ нь судалгаанд оролцогсдын гэр бүлийн орлогод 73 хувь нь маш их нөлөөлсөн, 21 хувь нь дунд зэрэг нөлөөлсөн байна. Иргэдийн 700 мянган төгрөг хүртэлх өрхийн орлоготой бүлэгт хамгийн их нөлөөлсөн байна. Насны ангиллаар авч үзвэл 40-49 насны, хувиараа бизнес эрхлэгчдийн өрхийн орлогод хамгийн их нөлөөлжээ.
4. Иргэдийн гэр бүлийн аль нэг гишүүн ажлаас халагдсан тохиолдолд одоо байгаа хуримтлалаараа ямар хугацаанд амьдрах талаар тодруулахад судалгаанд оролцогсдын 72 хувь нь хадгаламж байхгүй, 14 хувь нь 1 хүртэлх сарын хугацаанд амьдрах боломжтой байна.
5. Иргэдийн орлогыг хамгаалах чиглэлээр УИХ, Засгийн газраас гаргасан шийдвэрүүд нь иргэдийн орлогод хэрхэн нөлөөлж байгааг тодруулахад судалгаанд оролцсон иргэдийн 45 хувь нь орлогод нөлөөлөхгүй, 25 хувь нь орлого нэмэгдэнэ гэж хариулсан бол 30 хувь нь гарсан шийдвэрийн талаар тодорхой мэдээлэлгүй байна.




1. Гэр бүлийн орлого дахь нөлөө

Covid-19 вирусийн халдвараас сэргийлэх арга хэмжээ нь гэр бүлийн орлогод нөлөөлсөн талаар тодруулахад судалгаанд оролцогсдын 73 хувь нь маш их нөлөөлсөн, 21 хувь нь дунд зэрэг нөлөөлсөн, 5 хувь нь бага нөлөөлсөн, 2 хувь нь нөлөөлөөгүй гэжээ.




Гэр бүлийн орлогын нөлөөллийг судалгаанд оролцогсдыг насны ангиллаар авч үзвэл 40-49 насны иргэдийн 76 хувь нь маш их нөлөөлсөн гэж хариулсан бол 60-аас дээш насны иргэдийн гэр бүлийн орлогын нөлөө нь бусад насны ангилалтай харьцуулахад харьцангуй бага байна.





Өрхийн гишүүдийн тооны ангиллаар авч үзвэл 7-с дээш ам бүлтэй гэр бүлд хамгийн их нөлөөлсөн бол ганц биеэр амьдардаг иргэдийн орлогын нөлөө бусад бүлэгтэй харьцуулахад бага нөлөөтэй байна.




Гэр бүлийн орлогын түвшингээр ангилан харвал 400 мянган төгрөг хүртэлх орлоготой иргэдэд хамгийн их нөлөөлсөн ба эдгээр иргэдийн 87 орчим хувь нь “маш их нөлөөлсөн” гэж хариулжээ. Харин өрхийн орлого нь 5 сая төгрөгөөс дээш иргэдийн орлогын нөлөө харьцангуй бага байна.





Орлогын нөлөөг иргэдийн ажил эрхлэлтийн байдлаар авч үзвэл судалгаанд оролцсон хувиараа бизнес эрхлэгчдийн 90 хувь нь гэр бүлийн орлогод “маш их нөлөөлсөн” гэж үзжээ. Харин олон улсын байгууллага, төрийн байгууллагад ажилладаг иргэдийн гэр бүлийн орлогын нөлөө харьцангуй бага байна.






2. Гэр бүлийн ба иргэдийн хуримтлал

Тухайн өрхийн аль нэг гишүүн ажлаас халагдсан тохиолдолд танай гэр бүл хадгаламжаараа ямар хугацаанд амьдрах талаар тодруулан асуухад судалгаанд оролцогсдын 72 хувь нь хадгаламж байхгүй гэж хариулсан бол 14 хувь нь 1 хүртэлх сар, 8 хувь нь 3 хүртэлх сарын хугацаанд амьдрах боломжтой гэж хариулсан байна. Өрхийн хуримтлалаар 1 жилээс дээш хугацаанд амьдарна гэж нийт судалгаанд оролцсон иргэдийн дөнгөж 0.4 хувь нь хариулсан байна.



Иргэдийн хадгаламжтай эсэх, одоо байгаа хуримтлалаараа амьдрах боломжтой хугацааг насны бүлгээр ангилан харвал 25-34 насны иргэдийн 73 хувь нь ямар нэг хадгаламж байхгүй гэжээ. Мөн 15-59 насны ангилалд багтах иргэдийн 14 орчим хувь нь одоо байгаа хуримтлалаараа 1 хүртэлх сар амьдрах боломжтой гэж хариулжээ.






Гэр бүлийн орлогын түвшнгээр ангилан харвал судалгаанд оролцсон 700 мянган төгрөг хүртэлх өрхийн орлоготой иргэдийн дунджаар 85 хувь нь хадгаламж байхгүй, дөнгөж 10 орчим хувь нь одоо байгаа хуримтлалаараа 1 хүртэлх сар амьдрах боломжтой ба хамгийн бага хуримтлалтай иргэд байна. Түүнчлэн ажлын байрны цомхотгол хийгдсэн тохиолдолд 700 мянган төгрөг хүртэлх өрхийн орлоготой иргэд эрсдэлд хамгийн ихээр өртөх магадлалтай байна.



Ажил эрхлэлтийн байдлаар авч үзвэл хувийн компанид ажилладаг, хувийн бизнес эрхэлдэг иргэдийн 69 хувь нь хадгаламж байхгүй, 15 хувь нь одоо байгаа хуримтлалаараа 1 хүртэлх сар, 10 хувь нь 2-3 сар амьдрах боломжтой байна.





3. Иргэдийн орлогыг хамгаалах арга хэмжээний үр нөлөө

Иргэдийн орлогыг хамгаалах чиглэлээр УИХ, Засгийн газраас гаргасан шийдвэрүүд нь иргэдийн орлогод хэрхэн нөлөөлж байгаа талаар тодруулахад судалгаанд оролцсон иргэдийн 45 хувь нь орлогод нөлөөлөхгүй, 25 хувь нь орлого нэмэгдэнэ гэж хариулсан бол 30 хувь нь гарсан шийдвэрийн талаар тодорхой мэдээлэлгүй байна.



Насны ангиллаар авч үзвэл 50 ба түүнээс дээш насны иргэдийн орлогын өөрчлөлт харьцангуй бага байна. Харин 15-24 насны иргэд УИХ, Засгийн газраас гарсан шийдвэрүүдийн талаар мэдээлэл багатай байна.

Иргэдийн орлогын түвшингээр авч үзвэл 2-5 сая төгрөгийн өрхийн орлоготой иргэдийн 55 орчим хувь нь өрхийн орлогод ямар нэг өөрчлөлт байхгүй, 700 мянган төгрөг хүртэлх орлоготой иргэдийн дунджаар 31 орчим хувь нь тодорхой мэдээлэл байхгүй гэж хариулсан бол 5 сая төгрөгөөс дээш орлоготой иргэдийн орлого нэмэгдэнэ гэжээ.

Судалгаанд оролцогсдын ажил эрхлэлтийн байдлаар авч үзвэл хувиараа бизнес эрхлэгчдийн 53 хувь, тэтгэврийн иргэдийн 58 хувь нь орлогын өөрчлөлтгүй гэж төсөөлж байна. Хувийн компанид ажилладаг иргэдийн 31 хувь, төрийн бус байгууллагад ажилладаг иргэдийн 30 хувь, төрийн өмчит аж ахуйн нэгжид ажилладаг иргэдийн 26 хувь нь гэр бүлийн орлого тодорхой хэмжээгээр өснө гэжээ.





4. Оролцогчдын мэдээлэл

Судалгааг 2020 оны 4 сарын 10-13-ны өдрүүдэд, цахим асуулгын хэлбэрээр явуулж нийт 10105 иргэдийг хамруулан, түүврийн шаардлага хангасан 9043 иргэний мэдээлэлд үндэслэн үр дүнг нэгтгэв.

Судалгаанд оролцсон иргэдийн 48 хувь нь 700 мянган төгрөг хүртэлх өрхийн орлоготой, 25 хувь нь 701 мянга-1 сая хүртэлх, 21 хувь нь 1-2 сая төгрөгийн, 5 хувь нь 2-5 сая төгрөгийн, 1 хувь нь 5 саяас дээш өрхийн орлоготой байв. Насны бүлгээр авч үзвэл 43 хувь нь 25-34 насны, 26 хувь нь 40-49 насны, 18 хувь нь 35-39 насны, 6 хувь нь 50-59 насны ангилалд байсан бол 1 хувь нь 60-аас дээш насны, 7 хувь нь 15-24 насны иргэд хамрагдсан байна. Мөн иргэдийн ба 40 хувь нь хувийн компанид, 16 хувь нь хувиараа бизнес эрхэлдэг, 16 хувь нь төрийн байгууллагад ажилладаг бол 13 хувь нь ажилгүй иргэд байна.

Судалгаанд оролцогчдын 25 хувь нь эрэгтэй, 75 хувь нь эмэгтэй байсан ба 69 хувь нь Улаанбаатар хотод, 31 хувь нь орон нутагт амьдардаг байв. Мөн эдгээр иргэдийн 67 хувь нь 4-6 ам бүлтэй, 26 хувь нь 2-3 ам бүлтэй, 5 хувь нь 7-оос дээш ам бүлтэй, 2 хувь нь ганцаар амьдардаг байна. Боловсролын түвшингээр авч үзвэл 63 хувь нь дээд, 23 хувь нь бүрэн дунд, 9 хувь нь ТМС/МСҮТ, 4 хувь нь бүрэн бус, 0.4 хувь нь бага боловсролтой иргэд тус судалгаанд хамрагджээ.

